



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/431

Хэрлэн сум

Мал, тэжээвэр амьтан, хашаа,  
худгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "г", 30 дугаар зүйлийн 30.1.15, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт өмчийн бүх хэлбэрийн мал, тэжээвэр амьтан, хашаа худгийг тоолох ажлыг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд явуулсугай.

2. 2017 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга:	Т.Өлзийсүрэн	Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Батхишиг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ж.Энх-Амгалан	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Д.Тулга	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
	Б.Дархантер	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Д.Батжаргал	Онцгой байдлын газрын дарга

Д.Баярхүү	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга
Л.Чулуун	Ус цаг уур орчны шиожилгээний төвийн дарга
Ц.Идэрбат	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч

3. Жилийн эцсийн мал тооллогод зарцуулах хөрөнгийг хэвсрэлтаар баталсугай.
4. Багт ажиллах тоочдыг семинар гарын авлагаар хангаж, хугацаанд нь гаргах, оторт яваа малчдыг тухайн орон нутгийнх нь удирдлагатай холбогдож тооллогод бүрэн хамруулах, гүйцэтгэлийн хяналтыг сайн зохион байгуулахыг сумдын Засаг дарга, хот, тосгоны Захирагч нарт даалгасугай.
5. Мал тооллогод зарцуулах 4600000 /дөрвөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг аймгийн нөөц сангийн мал тооллолын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.
6. Жилийн эцсийн мал тооллогын ажилд комиссын гишүүдийг ажил хэрэгчээр оролцуулж, сумдын тооллогын явцад анхаарч хяналт тавьж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.
7. Мал тооллоготой холбоотой сургалт болон маягт заавар татах ажлыг 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор зохион байгуулах, хяналтын тооллогыг чанартай хийж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сумдын тооллогын комисст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.САНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны  
 // дугаар сарын 29 өдрийн 111 дугаар  
 захирамжийн хоёрдугаар хайсралт

2017 оны мал тооллогод зарцуулах зардлын тооцоо

Д/д	Сумдын нэр	Олгох зардал /мян.төг/	Хяналтаар ажиллах комиссын зардал /мян.төг/	Бүгд
1	Галшар	180		
2	Баянхутаг	140		
3	Баянменх	140		
4	Дархан	140		
5	Дэлгэрхаан	210		
6	Жаргалтхаан	150		
7	Цэнхэрмандал	140		
8	Өмнөдэлгэр	210		
9	Батширээт	160		
10	Биндэр	170		
11	Баян-Адрага	140		
12	Дадал	190		
13	Норовлин	160		
14	Батноров	180		
15	Баян-Овоо	160		
16	Мөрөн	160		
17	Хэрлэн	230		
18	Бор-Өндөр	130		
19	Бэрх	130		
20	Гурванбаян	130		
21	Статистикийн хэлтэс	0	1 350	1350 0
	Дүн	3 250	1 350	4600 0